



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/527

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн түүхт 40 жилийн ой болон Эрүүл мэндийн ажилтны өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажил үйлсээрээ хамт олноо манлайлан ажиллаж буй нэр бүхий иргэдийг нарыг Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 150 000 төгрөг хавсралтаар баталж, зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 150 000 төгрөг /Нэг зуун тавин мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
08 дугаар сарын 14-ний өдрийн
А/527 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Б.Буянхишиг	Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн үйлчлэгч	30000
2	И.Отгонцагаан	Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн үйлчлэгч	30000
3	Т.Батцэнгэл	Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн үйлчлэгч	30000
4	Д.Цэцэнхүү	"Цуцаагүй жигүүр" ТББ-ын гишүүн, Эрүүл мэндийн байгууллагын ахмад ажилтан	30000
5	Б.Цэндсүрэн	"Цуцаагүй жигүүр" ТББ-ын гишүүн, Эрүүл мэндийн байгууллагын ахмад ажилтан	30000
Дүн			150 000